



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/09-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ц.Ундраа
Утас: 70362442 Цахим хаяг: undraats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
4. Аудитын тайлан	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.23 № СЭА-2024/09-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхонтуул сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 527,339.3 мянган төгрөгийн татварын орлого, 25,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 552,339.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 690,422.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 24.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 71.3 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 28.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв зэрэг улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс нийт 570,965.5 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 483,758.9 мянган төгрөг зарцуулж, төсвийг 87,206.6 мянган төгрөг буюу 15.3 хувиар хэмнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхонтуул сумын Засаг дарга нь тайлант онд 14 зорилт, 185 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 80.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	979,221.80	1,151,961.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	806,826.80	877,874.90
33	АВЛАГА	143,615.80	204,118.50
35	БАРАА МАТЕРИАЛ	28,779.30	69,967.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,409,224.40	8,848,225.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,409,224.40	8,848,225.90
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	2,402,345.70	8,842,413.90
39300	Биет бус хөрөнгө	6,878.70	5,812.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,388,446.20	10,000,186.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	84,240.10	50,717.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,240.10	50,717.90
41300	Өглөг	84,240.10	50,717.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,304,206.10	9,949,468.90
51	Засгийн газрын хувь оролцоо	3,304,206.10	9,949,468.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	462,549.00	462,549.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,230,313.10	8,875,575.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	611,344.00	611,344.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,388,446.20	10,000,186.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,578,234.80	8,956,511.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	406,535.00	661,437.20
110	Орлогын албан татвар	235,241.20	270,652.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	235,241.20	311,172.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0
113	Хөрөнгийн албан татвар	140,458.30	216,590.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,835.50	174,193.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	403,155.60	6,757,618.50

120	Нийтлэг татварын бус орлого	403,155.60	6,757,618.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,768,544.20	1,537,455.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,625,553.50	1,792,290.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,625,553.50	1,792,290.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,449,146.50	1,785,455.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,189.50	550,637.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,088.00	68,955.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	475,300.60	78,777.10
2104	Хангамж, бараа материалын зардал	30,476.20	36,278.20
2105	Норматив зардал	1,426.20	270
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,899.00	6,152.50
2107	Томилолт, зочны зардал	3,095.80	5,796.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,746.40	499,583.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	428,924.80	539,005.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,176,407.00	6,835.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	952,681.30	7,164,221.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,979,874.00	518,958.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,027,192.70	6,645,262.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,368,817.30	0	7,368,817.30
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,304,206.10	0	3,304,206.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,331,398.80	0	7,331,398.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-37,418.50	0	-37,418.50
9	Тайлант үеийн үр дүн	-4,027,192.70	0	-4,027,192.70
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,304,206.10	0	3,304,206.10
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,949,468.90	0	9,949,468.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,304,206.10	0	3,304,206.10
19	Тайлант үеийн үр дүн	6,645,262.80	0	6,645,262.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,312,436.50	2,259,798.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	406,535.00	661,437.20
110	Орлогын албан татвар	235,241.20	270,652.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	235,241.20	311,172.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-40,520.30
113	Хөрөнгийн албан татвар	140,458.30	216,590.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,835.50	174,193.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,192.70	2,721.90
1181	Газрын төлбөр	21,621.80	146,410.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,021.00	25,062.00
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,782.20	99,480.50
120	Нийтлэг татварын бус орлого	98,782.20	99,480.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,807,119.30	1,498,880.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,337,537.40	1,358,005.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,337,537.40	1,358,005.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,103,347.20	1,351,170.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,583.80	547,768.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,479.00	68,954.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,989.90	73,382.60
2104	Хангамж, бараа материалын зардал	27,480.70	30,444.10
2105	Норматив зардал	1,426.20	270
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,399.00	6,152.50
2107	Томилолт, зочны зардал	3,095.80	5,796.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,961.30	508,222.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,931.60	110,179.10
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,234,190.20	6,835.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	974,899.10	901,793.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	659,070.10	680,744.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	659,070.10	680,744.90
2200	Дотоод эх үүсвэрээр	659,070.10	680,744.90
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-659,070.10	-680,744.90

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-150,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	150,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	315,829.00	71,048.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	490,997.70	806,826.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	806,826.80	877,874.90

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,971,343.70	2,119,204.89	852,138.81	71.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,527,559.00	1,295,459.84	232,099.16	84.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,518,125.40	1,288,624.84	229,500.56	84.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,774.60	547,418.32	46,356.29	92.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,297.40	68,954.65	5,342.75	92.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	623,492.90	540,103.98	83,388.92	86.6
2104	Хангамж, бараа материалын зардал	37,666.80	26,422.61	11,244.19	70.1
2105	Норматив зардал	875.20	270.00	605.20	30.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,148.90	27,190.13	28,958.77	48.4
2107	Томилолт, зочны зардал	7,661.20	5,796.30	1,864.90	75.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,725.60	21,357.89	14,367.71	59.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,482.80	51,110.96	37,371.84	57.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,433.60	6,835.00	2,598.60	72.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,433.60	6,835.00	2,598.60	72.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,280,887.70	673,745.04	607,142.66	52.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	162,897.00	150,000.00	12,897.00	92.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,971,343.70	2,233,905.76	737,437.95	75.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,260,465.70	2,183,593.65	76,872.05	96.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	593,635.60	593,635.60	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	710,878.00	50,312.10	660,565.90	7.0

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,500.00	50,312.10	187.90	99.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	660,378.00	0	660,378.00	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	67	67		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3		
610001	Төсвийн байгууллага	3	3		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32	32		
620001	Удирдах ажилтан	8	8		
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13		
620003	Үйлчлэх ажилтан	11	11		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6		
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1		
660005	Хөдөлмөрийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч /Бусад/	1	1		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,745.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,745.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,745.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350.00
210104	Урамшуулал	350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,021.47
210401	Бичиг хэрэг	1,394.00
210402	Тээвэр, шатахуун	2,627.47
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,106.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,106.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,268.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,268.01
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,745.48
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,745.48
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,972.62
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,804.85
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,968.01

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхонтуул сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Дээд шатны байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх өөрийн сумын онцлогт тохирсон бодлогыг боловсруулах, төрийн үйлчилгээг шинэлэг хэлбэрээр хүртээмжтэй хүргэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд 2023 оныг “Бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжих, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг ханган “Хариуцлагатай уул уурхай”-г хөгжүүлж хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2023 онд Орхонтуул сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхонтуул сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,611,740.7 мянган төгрөгөөр буюу 2,9 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	806,826.80	877,874.90	71,048.10
Авлага	143,615.70	204,118.50	60,502.80
Бараа материал	28,779.30	69,967.60	41,188.30
Үндсэн хөрөнгө	2,409,224.40	8,848,225.90	6,439,001.50
Нийт хөрөнгө	3,388,446.20	10,000,186.90	6,611,740.70
Өр төлбөр	84,240.10	50,718.00	-33,522.10
Засгийн газрын хувь оролцоо	3,304,206.10	9,949,468.90	6,645,262.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,388,446.20	10,000,186.90	6,611,740.70

Эх сурвалж: Орхонтуул сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 877,874.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 71,048.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Банканд байгаа бэлэн мөнгө	806,826.80	877,874.90	71,048.10	
Төгрөг	806,826.80	877,874.90	71,048.10	
Төрийн сангийн харилцах	806,826.80	877,874.90	71,048.10	
Дүн	806,826.80	877,874.90	71,048.10	

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 433,531.5 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 379,873.4 мянган төгрөг / Хэрэгжээгүй 7 төсөл арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл болон зураг төсвийн зардал 28,653.5 мянган төгрөг, гэрээний зөрүү 28,398.1 мянган /, ХХС-ийн үлдэгдэл 14,612.7 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 49,857.3 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 204,118.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,502.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилсагсадтай холбогдсон авлага	600.00	-	-600.00
Зээлийн хүүгийн авлага	4,200.30	1,695.70	-2,504.60
Байгууллагаас авах авлага	39,153.90	578.70	-38,575.20
Хувь хүмүүст олгосон зээл	4,906.80	3,366.80	-1,540.00
Хувь хүмүүст олгосон зээл	94,754.80	198,477.30	103,722.50
Дүн	143,615.80	204,118.50	60,502.70

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага данс 60,502.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ХХС-аас шинээр 2 ААН болон 2 иргэнд нийт 150,000.0 мянган төгрөгийн зээл олгосноос шалтгаалсан байна. Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 97.2 хувь буюу 198,477.3 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Тайлант онд насжилт өндөртэй /5-аас дээш жил/ ХХС-ийн зээлийн авлагыг барагдуулахаар 10 иргэнтэй холбоотой 46,277.5 мянган төгрөгийн нэхэмжлэлийг холбогдох шатны шүүхэд хүргүүлсэн бөгөөд Шүүхийн шийдвэрийн дагуу 48,782.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 69,967.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 41,188.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.00	2,821.70	2,821.70
Тусгай зориулалтын материал		2821.7	2,821.70
Хангамжийн материал	28,779.30	67,145.90	38,366.60
Бичиг хэргийн материал	2,580.00	2,540.20	-39.80
Аж ахуйн материал	3,141.10		-3,141.10
Сэлбэг хэрэгсэл			0.00
Хүнсний материал			0.00
Бусад хангамжийн материал	23,058.20	64,605.70	41,547.50
Дүн	28,779.30	69,967.60	41,188.30

Эх сурвалж: Орхонтуул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 41,188.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 215,257.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 618,991.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн болон 415,836.5 мянган

төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагуудад шилжүүлэн, 377,223.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 8,848,225.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,439,001.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,402,345.70	8,842,413.90	6,440,068.20
Барилга, байгууламж, орон сууц	1,476,944.80	1,382,715.60	-94,229.20
Авто-тээврийн хэрэгсэл	79,341.40	225,920.00	146,578.60
Машин тоног төхөөрөмж(компьютер)	74,819.50	153,497.30	78,677.80
Тавилга, аж ахуйн эд хогшил	23,876.50	18,307.50	-5,569.00
Зам, гүрийн байгууламж	437,954.50	433,384.70	-4,569.80
Бусад үндсэн хөрөнгө	309,409.00	276,108.60	-33,300.40
Дуусаагүй барилга		6,352,480.20	6,352,480.20
Биет бус хөрөнгө	6,878.70	5,812.00	-1,066.70
Программ хангамж	2,066.70	1,000.00	-1,066.70
Бусад биет бус хөрөнгө	4,812.00	4,812.00	0.00
Дүн	2,409,224.40	8,848,225.90	6,439,001.50

Эх сурвалж: Орхонтуул сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 6,439,001.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,999.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 55,949.6 мянган төгрөгийн, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 254,735.7 мянган төгрөгийн ажил гүйцэтгэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 6,352,480.2 мянган төгрөгийн Орхон голын төмөр бетонон гүүрийг дуусаагүй барилга байгууламжид бүртгэсэн зэрэг нийт 6,670,165.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар тогтоолоор 20,446.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан, 210,717.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 50,717.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,522.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	83,910.10	50,717.90	-33,192.20
Хувь хүмүүст төлөх өглөг	330.00	0	-330.00
Дүн	84,240.10	50,717.90	-33,522.20

Эх сурвалж: Орхонтуул сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээний барьцааны 49,857.3 мянган төгрөгийн, ерөнхий орлогоос байгууллагад төлөх өглөг 281.9 мянган төгрөгийн, ИТХ-ын ХХОАТ-ын 578.7 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,949,468.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,645,262.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	462,549.00	462,549.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	2,230,313.10	8,875,575.90	6,645,262.80
Өмнөх үеийн үр дүн	6,257,505.80	2,230,313.10	-4,027,192.70
Тайлант үеийн үр дүн	-4,027,192.70	6,645,262.80	10,672,455.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	611,344.00	611,344.00	0.00
Дүн	3,304,206.10	9,949,468.90	6,645,262.80

Эх сурвалж: Орхонтуул сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын “Орхонтуул сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 80 дугаар тогтоолоор тайлант онд 527,339.3 мянган төгрөгийн татварын орлого, 25,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого нийт 552,339.3 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **690,422.6** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 24.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	527,339.30	661,437.20	134,097.90	125.4
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	174,401.30	250,820.30	76,419.00	143.8
Үйл ажиллагааны орлого	22,000.00	23,929.10	1,929.10	108.8

Хөрөнгийн орлого	22,000.00	31,814.90	9,814.90	144.6
Хөрөнгө борлуулсны орлого	5,000.00	4,608.60	-391.40	92.2
ХХОАТ-ын буцаалт	-20,000.00	-40,520.30	-20,520.30	202.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	18,000.00	12,153.40	-5,846.60	67.5
Бууны албан татвар	1,200.00	960.00	-240.00	80.0
Малд ногдуулах албан татвар	270,000.00	203,477.30	-66,522.70	75.4
Улсын тэмдэгтийн хураамж	1,700.00	559.90	-1,140.10	32.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	225.00		-225.00	0.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,000.00	2,162.00	-1,838.00	54.1
Газрын төлбөр	28,633.00	146,410.00	117,777.00	511.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	180.00	25,062.00	24,882.00	13923.3
Татварын бус орлого	25,500.00	28,985.40	3,485.40	113.7
Торгуулийн орлого	10,000.00	9,197.30	-802.70	92.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	500.00		-500.00	0.0
Бусад орлого	15,000.00	19,788.10	4,788.10	131.9
Нийт орлогын дүн	552,839.30	690,422.60	137,583.30	124.9

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, газрын төлбөрийн орлого, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн орлого тус тус давж биелсэн байна.

Малын тоо толгойн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 76,419.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2023 оны 7 дугаар сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан
- Газрын төлбөрийн орлого 117,777.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд газар эзэмших болон ашиглагч иргэний бүртгэлийг шинэчлэн хийсний дүнд иргэд урьд онуудын газрын төлбөрөө барагдуулснаас
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 24,882.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь бэлчээр болон хадлан сайн ургаж иргэд төлбөр хураамжаа барагдуулснаас шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Малын тоо толгойн албан татвар 66,522.7 мянган төгрөгөөр тасарсан нь 2022 оны малын тооллогод үндэслэн орлогыг төлөвлөлгүй хэт өндрөөр төлөвлөснөөс,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 5,846.6 мянган төгрөгөөр тасарсан нь хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,806,543.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,077,577.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 490,945.7 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 56 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 549,238.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 191,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 112,652.1 мянган төгрөгийг, Малын тоо толгойн татварын урьд оны үлдэгдлээс 138,000.0 мянган төгрөгийг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 164,800.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг **2,724,213.7** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгож, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 36,912.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 80 дугаар тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

Төсвийн орлогын өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 3,601.3 мянган төгрөгөөр,
- Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлийг 103,926.0 мянган төгрөгөөр
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 36,912.9 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 102,689.8 мянган төгрөгөөр зэрэг нийт **247,130.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- Сумын ОНХС-ийн зардлыг 102,689.8 мянган төгрөгөөр,
- Сумын ОНХО-аар хийгдэх төсөл арга хэмжээний зардлыг 66,600.0 мянган төгрөгөөр,
- Сумын ЗДТГ-ын болон ИТХ-ын цалингийн зардлыг 77,840.4 мянган төгрөгөөр зэрэг нийт **247,130.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт эх үүсвэр болон зардлыг **2,971,343.7** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,971,343.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,495,656.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,280,887.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 194,800.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 1,114,490.8 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, сумын татварын болон татварын бус орлогоор 552,839.3 мянган төгрөгийг, аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 593,635.5 мянган төгрөг,

орон нутгийн нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 294,925.9 мянган төгрөгийг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 112,652.1 мянган төгрөгийг, малын тоо толгойн албан татварын урьд оны үлдэгдлээс 138,000.0 мянган төгрөгийг, ХХС-ийн зээлийн эх үүсвэрээс 194,800.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	112,996.20	70,963.80	42,032.40	62.8
2	Засаг даргын тамгын газар	783,598.90	584,901.60	198,697.30	74.6
	Захирагчийн алба	224,695.40	208,686.20	16,009.20	92.9
3	Орон нутгийн хөгжлийн сан	1,114,287.70	618,991.30	495,296.40	55.6
4	Хоршоо хөгжүүлэх сан	164,800.00	151,903.00	12,897.00	92.2
	Сумын ЕБС	198,886.20	183,297.10	15,589.10	92.2
5	Рашаант тосгоны ЕБС	165,420.50	136,294.50	29,126.00	82.4
	Сумын ЭМТ	51,933.60	46,912.10	5,021.50	90.3
6	Рашаант тосгоны ЭМТ	42,664.30	31,016.60	11,647.70	72.7
	Сумын цэцэрлэг	45,575.30	35,782.10	9,793.20	78.5
7	Сумын соёлын төв	36,338.80	33,731.50	2,607.30	92.8
8	Рашаант тосгоны соёлын төв	30,146.80	16,725.00	13,421.80	55.5
	Нийт дүн	2,971,343.70	2,119,204.80	852,138.90	71.3

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 897,767.7 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 690,422.6 мянган төгрөг, ОНХС-ийн урсгал шилжүүлэг 593,635.5 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 48,782.1 мянган төгрөг, ОНХС-ийн эх үүсвэрээс 1,030.0 мянган төгрөгийг, өөрийн орлогоос 500.0 мянган төгрөг зэрэг нийт 2,233,905.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж 2,119,204.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,119,204.8 мянган төгрөг буюу 71.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 356,852.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 495,286.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт 33 төсөл, арга хэмжээнд 1,280,887.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 23 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж 673,745.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 2,804.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 47,968.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс 3,972.6 мянган төгрөг зэрэг нийт **54,745.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 350.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 4,021.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 3,106.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 47,268.0 мянган төгрөг зэрэг нийт **54,745.4** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,280,887.6 мянган төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр шууд худалдан авах 18, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 11, нээлттэй тендер шалгаруулах 4, нийт 33 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Орхонтуул сумын 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		ШХА		Үүнээс Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	27	1,114,287.6	14	206,652.10	9	424,035.5	4	483,600.0
Сумын ОНХО	6	166,600.0	4	52,000.00	2	114,600.0		
НИЙТ ДҮН	33	1,280,887.6	18	258,652.10	11	538,635.5	4	483,600.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхонтуул сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,625,553.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 26,255.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Батлагдсан төсвийг 852,138.8 мянган төгрөгөөр буюу 28.7 хувиар хэмнэсэн ,*
- *Автомашинуудад цэнхэр дэвсгэр бүхий дугаар авсан,*
- *Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,*
- *Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөлгүй ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	168	158	10	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	147	24	
3	Засаг даргын Тамгын газар	145	135	10	
4	Захирагчийн алба	171	165	6	
	Нийт дүн	655	605	50	

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 655 мэдээллээс 605 мэдээллийг хугацаанд нь, 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох баримтын хүрээнд тулган шалгахад дунджаар 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	6,971.2	2	6,971.2	100.0
Албан шаардлага	6	14,508.6	5	12,110.6	83.5
Нийт дүн	8	21,479.8	7	19,081.8	88.8

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан зөрчилд дараах шийдлийг хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй тайланд онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн сумын Санхүүгийн албаны дарга С.Эрдэнэчимэг, нягтлан бодогч Б.Хоролсүрэн, С.Баасансүрэн нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **6,352,480.2** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулаагүй алдаа:

- Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Орхон голын төмөр бетонон гүүрийн 6,352,480.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бараа материалын дансанд бус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх дуусаагүй төсөл, арга хэмжээг бараа материалын дансанд бүртгэж, 2024 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **146,515.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **22,425.2** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **124,089.9** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага:

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс ИТХ нь **578.7** мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, Захирагчийн алба нь ХХОАТ-ын **578.7** мянган төгрөгийн авлага тус тус үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өглөг үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Анхан шатны баримтын бүрдэлгүй дараах **10,990.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

ОНХС:

- Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх “**Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын шатахуун болон сургалт, сурталчилгааны зардал**”-д тусгагдсан 7,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй буюу ажил гүйцэтгүүлэх гэрээ, гүйцэтгэсэн ажлын тайлангүйгээр,

ЗДНХ:

- Шагнал хүлээн авсан хүний гарын үсэггүйгээр “Сумын аварга малчин өрх”-ийн арга хэмжээнд **2,280 .0** мянган төгрөг, “Ургацын баяр”-ын арга хэмжээнд **1,710.0** мянган төгрөг

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Дараах байгууллагууд нь **10,277.8** мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

ЗДТГ:

- Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс гадаад томилолтын зардалд 1,905.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 2,500.0 мянган төгрөг зэрэг нийт **4,405.0** мянган төгрөгийг,
- Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах цэвэрлэх үйлчилгээний зардлаас 1,561.3 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, хөдөлмөр хамгаалал хэрэглэлийн зардлаас 661.5 мянган төгрөгийг урсгал засварын зардалд зэрэг нийт **2,222.8** мянган төгрөгийг,

ИТХ:

- Бараа үйлчилгээний бусад зардлаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 100.0 мянган төгрөг, өөрийн чиг үүрэгт хамааралгүй гоц халдварт мялзан өвчний зардалд 3,550.0 мянган төгрөг зэрэг нийт **3,650.0** мянган төгрөгийг,

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай төсвийн зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Сумын ОНХС-ийн хөрөнгө болох Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх “**Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын шатахуун болон сургалт, сурталчилгааны зардал**”-ын 7,000.0 мянган төгрөгийг сумын Засаг дарга бус төсөв захиран зарцуулах эрхгүй сумын ХАА-н тасгийн даргын зөвшөөрлөөр зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх “*Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна*” 14.1.20 дахь “*аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн сумын ХАА-н тасгийн даргад хариуцлага тооцох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 9 нэр төрлийн 124,089.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”* гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	6,352,480.2			1	6,352,480.2			1	6,352,480.2		
Дүн	1	6,352,480.2			1	6,352,480.2			1	6,352,480.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	141,707.7			3	17,617.8	1	124,089.9				
ИТХ	2	4,228.7			2	4,228.7						
Захирагчийн алба	1	578.7			1	578.7						
Дүн	7	146,515.1			6	22,425.2	1	124,089.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
ТТЗ нийт 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1						1				
Дүн											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Нийт дүн	1						1				